



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/176

Чойр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 07 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Монгол Улсын “Арслан” цолнуудын нэрэмжит үндэсний бөхийн барилдааныг тохиолдуулан тус аймгаас төрөн гарсан Монгол Улсын “Арслан” Давгадоржийн Азжаргалд хүндэтгэл үзүүлж 1,000,000 (нэг сая) төрөг, Баяр наадмын бэлтгэл, сургуулилтыг хангахад дэмжлэг үзүүлж, аймгийн үндэсний бөхийн холбоонд 10,000,000 (арван сая) төгрөгийг тус тус олгосугай.

2.Дээрх зардалд зарцуулагдах 11,000,000 (арван нэгэн сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)–д зөвшөөрсүгэй .

ЗАСАГ ДАРГА

Г.БАТЗАМ